

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт,
Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон
“Мандал Даатгал” ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан
дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2019 оны 4 сарын 29-ны өдрийн Хувьцаа
эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мандал Даатгал” ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт
1 ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

"Мандал Даатгал" ХК-ийн 2019 оны 4 сарын 29-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 19/2019 тоот тогтоолын Хавсралт 1



2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Мандал Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл

Мандал Даатгал ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2018 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Мандал Даатгал ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Мандал Даатгал ХК-ийн ТУЗ нь 2017 оны 12 сарын 12-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар Мандал Даатгал ХК-ийн 2018 оны Бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. ТУЗ-ийн баталсан 2018 оны Бизнес төлөвлөгөөний гол зорилго нь компани зах зээлд эзлэх байр сууриа хадгалан илүү чанартай бизнес хийж, компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх байсан бөгөөд үүний хүрээнд үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, ажилтнуудын ур чадварын сайжруулах болон IPO хийх гэсэн гурван төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна.

Мандал Даатгал ХК 2018 онд нийт 27,8 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллаж, бизнес төлөвлөгөөний биелэлт 113%, цэвэр ашиг 3.9 тэрбум төгрөгт хүрч ашгийн төлөвлөгөө 190%-ийн гүйцэтгэлтэй гарлаа.

2018 оны 3-р улиралд амжилттай IPO хийж, олон нийтэд компанийн нийт хувьцааны 25 хувийг эзэмшүүлэн 7.5 тэрбум төгрөгийн санхүүжилт татсанаар нээлттэй хувьцаат компани боллоо. Мөнгөн хөрөнгө нэмэгдсэнээр хөрөнгө оруулалтын орлого өмнөх оноос 83 хувиар өсч 2018 онд хөрөнгө оруулалтаас 2.2 тэрбум төгрөгийн орлого олсон байна. Мөн нийт хөрөнгө 33.8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 57% өссөн үзүүлэлттэй байна.

2018 он Мандал Даатгал ХК-ийн хувьд амжилттай жил байсан байсан бөгөөд гүйцэтгэх удирдлагын баг төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж ТУЗ-өөс дүгнэж байна.

Иймд Мандал Даатгал ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2017 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

2019 оны 3 дугаар сарын 19 өдөр

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн хувьцааг хуваах, дүрэмд
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.6 дах заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7.1, 7.7.5, дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2019 оны 4 сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мандал Даатгал” ХК-ийн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 6,243,016 ширхэг энгийн хувьцааны нэгж хувьцаа бүрийг 100 хувааж нэр бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 624,301,600 ширхэг энгийн хувьцаа болгон хуваасугай.
2. “Мандал Даатгал” ХК-ийн энгийн хувьцааг хувааж байгаатай холбогдуулан “Мандал Даатгал” ХК-ийн дүрмийн 4.1 дэх заалтыг доорх байдлаар өөрчлөн найруулсугай. Үүнд:

А/ 4.1. Хувьцаа эзэмшигчийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэнд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 624,301,600 ширхэг энгийн хувьцаа байна.

3. “Мандал Даатгал” ХК-ийн хувьцаа хуваах төслийг энэ тогтоолын Хавсралт 1 ёсоор баталсугай.
4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан компанийн хувьцааны нэрлэсэн үнэ, тоо өөрчлөгдөж дүрэмд нэмэлт өөрчлөлт орсныг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, холбогдох зөвшөөрөл авах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Жавхлан/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ



МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ХУВААХ ТӨСӨЛ

НЭГ. ЗОРИЛГО

Уг төслийн зорилго нь Компанийн нэгж хувьцааг хувааж, хувьцааны тоо хэмжээг нэмэгдүүлэн нэгж хувьцааны үнийг хямд болгосноор хөрөнгийн зах зээл дэх арилжааны идэвхийг нэмэгдүүлэн компанийн зах зээлийн үнэлгээг өсгөж хувьцаа эзэмшигчдийн баялгийг нэмэгдүүлэхэд оршино. Компанийн хувьцааг хувааснаар дараах ач холбогдолтой. Үүнд:

- Нэгж хувьцааны үнэ хямд болсноор жижиг хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэнэ.
- Хувьцааны арилжааны идэвх нэмэгдэж хөрвөх чадвар сайжирна.
- Арилжааны идэвх нэмэгдсэнээр хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хөрөнгө болон компанийн үнэлгээ нэмэгдэнэ.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ

“Компанийн тухай хууль”-ийн 51.3-т “Компани нь нэг хувьцааг тухайн төрлийн шинэ хоёр буюу түүнээс дээш тооны хувьцаанд хөрвүүлэх замаар өөрийн гаргасан хувьцаагаа хувааж болно” гэж заасны дагуу 2019 оны 4-р сарын 29 – ны өдрийн Мандал Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар, хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар Мандал Даатгал ХК-ийн нэгж хувьцааг 100 ширхэгт хуваах шийдвэр гаргав.

Хувьцааг хувааснаар арилжааны идэвх нэмэгдэж, компанийн үнэлгээ өснө гэж Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-өөс үзэж байна. Өмнөх жилүүдэд дараах 4 компани хувьцаагаа хувааснаас хойш 3 сарын дараа компанийн зах зээлийн үнэлгээнд гарсан өөрчлөлтийг хүснэгтээр харуулав.

Компанийн нэр	Хувьцаа хуваахаас өмнө		Хувьцаа хуваасны дараа		Зах зээлийн үнэлгээний өөрчлөлт
	Ханш	Зах зээлийн үнэлгээ	Ханш	Зах зээлийн үнэлгээ	
Сүү ХК	145,000	49,880,000,000	216	74,266,160,000	49%
Говь ХК	32,020	249,792,022,500	319	248,692,063,875	0%
АПУ ХК	3,970	422,480,076,541	444	472,039,011,464	12%
Таван толгой ХК	90,000	47,398,680,000	1,011	53,244,517,200	12%

2018 онд “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн ТОП-20 индекс 1.7 хувиар өссөн. Харин хувьцаагаа хуваасан дээрх 4 компанийн үнэлгээ 3 сарын дотор дунджаар 18 хувь өссөн байна. Уг үр дүнгээс компанийн хувьцааг хуваах нь зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлнө гэж дүгнэж байна.

ГУРАВ. ХУВЬЦАА ХУВААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

3.1. Компанийн хувьцаа хуваах тухай асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн “Компанийн тухай” хуулийн 51 дугаар зүйл болон 63 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

- 3.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг 2019 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар батална.
- 3.3. ТУЗ-ийн хурлын шийдвэр гарсны дараа 3 хоногийн дотор буюу 3 дугаар сарын 21-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын маягтын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д ТУЗ-ийн шийдвэрийн хуулбар болон хурлын тухай олон нийтэд хүргэх зарын загварын хамт хүргүүлнэ. Түүнчлэн уг журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтэд хүргэнэ.
- 3.4. Энэхүү төслийг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасны дагуу бүртгэх өдрөөр тасалбар болгон гаргасан тархалтын мэдээнд үндэслэн хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг Үнэт цаасны компаниудад хүргэх, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн цахим хуудсанд байршуулах, энэхүү төсөл болон хурлын материалтай хаана, хэдийд танилцаж болох талаар өдөр тутам хэвлэгдсэн гардаг 2 сонинд 2 удаагийн давтамжтай хэвлэн нийтлэх замаар хувьцаа эзэмшигчдэд танилцуулна.
- 3.5. Энэхүү төслийг хэлэлцэх хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр хуралдуулах болно.
- 3.6. Компанийн тухай хуулийн 51.5 болон 62.1.6-д заасны дагуу хувьцааг хуваах тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурал оролцож байгаа саналын эрхтэй хувьцааны дийлэнх олонх нь зөвшөөрсөн тохиолдолд хувьцааг хуваах тухай шийдвэр гарна.
- 3.7. Хувьцааг хувааснаар компанийн дүрэмд заасан хувьцааны тоо өөрчлөгдөх учраас компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн төслийг энэ журмын хавсралтаар хуралд оруулан батлах асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсны дараа хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д хүргүүлнэ. Үүний зэрэгцээ “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018/01 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 18 дугаар зүйлд заасан материалыг бүрдүүлэн хувьцааг хуваах асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтээ “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д хүргүүлнэ.
- 3.9. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аас хувьцааг хуваах замаар хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д мэдээлэл хүргүүлнэ.
- 3.10. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.2-т заасан журмын “Маягт СЗХ03101”-ын дагуу өргөдөл гарган, уг журамд заасан материалыг бүрдүүлэн Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, хувьцааны бүртгэлд орсон өөрчлөлтийг бүртгүүлнэ.
- 3.11. Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр гарсны дараа үнэт цаасны хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулна.
- 3.12. Эдгээр бүх өөрчлөлт хийгдсэний дараа Улсын бүртгэлийн албанд дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлснээр хувьцааг хуваах үйл ажиллагаа хэрэгжинэ.
- 3.13. Хувьцаа хуваах үйл ажиллагаа хэрэгжиж буйтай холбогдуулан эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувьцааны арилжааг түр зогсоож болно.

“Мандал Даатгал” ХК-ийн 2019 оны 4 сарын 29-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тоот тогтоолын Хавсралт 1

ДӨРӨВ. ХУВЬЦАА ХУВААХТАЙ ХОЛБООТОЙ ҮҮССЭН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Компанийн хувьцааг хуваах үйл ажиллагааг хэрэгжүүлж буйтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн зүгээс авч хэрэгжүүлэх ямарваа нэгэн эрх, үүрэг үүсэхгүй.

ТАВ. ХУВЬЦАА ХУВААХ ТООЦООЛОЛ

Компанийн хувьцааны өнөөгийн зах зээлийн ханш 5,000 орчим төгрөг байгааг харгалзан нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй хувьцаа нэг бүрийг нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 ширхэг хувьцаа болгон хөрвүүлэх замаар хувьцааг хуваана.

Ингэснээр одоо бүртгэлтэй байгаа компаний зарласан бөгөөд гаргасан 6,243,016 ширхэг хувьцаа нь нийт 624,301,600 ширхэг болж өөрчлөгдөх болно.

Үзүүлэлт	Хуваахаас өмнө	Хуваасны дараа
Нийт гарагсан хувьцаа	6,243,016 ширхэг	624,301,600 ширхэг
Нэг хувьцааны нэрлэсэн үнэ	1,000 төгрөг	10 төгрөг
Хувьцаат капиталын дүн	6,243,016,000 төгрөг	6,243,016,000 төгрөг
Хаалтын ханш - Бүртгэлийн өдрөөр	-	-
Зэх зээлийн үнэлгээ /2019-03-31/	31,964,241,920 төгрөг	-